210105	Гэрээт ажлын хөлс	968,108,800.00	878,462,601.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,082,036,900.00	4,735,829,364.64
210201	Тэтгэврийн даатгал	3,608,622,600.00	3,394,519,511.01
210202	Тэтгэмжийн даатгал	346,206,500.00	319,290,011.09
210203	ҮОМШӨ-ний даатгал	329,795,500.00	295,524,325.49
210204	Ажилгүйдлийн даатгал	84,809,300.00	71,781,432.59
210205	Эрүүл мэндийн даатгал	712,603,000.00	654,714,084.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	6,106,810,900.00	5,669,286,049.13
210301	Гэрэл, цахилгаан	651,916,100.00	533,702,478.28
210302	Түлш, халаалт	4,918,901,900.00	4,707,964,688.02
210303	Цэвэр, бохир ус	521,300,400.00	414,726,382.83
210304	Байрны түрээс	14,692,500.00	12,892,500.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,567,885,200.00	2,345,393,986.61
210401	Бичиг хэрэг	264,115,900.00	251,711,152.99
210402	Тээвэр, шатахуун	1,146,730,200.00	1,034,279,047.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	284,841,000.00	267,180,113.72
210404	Ном, хэвлэл	146,347,100.00	112,649,399.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгах	258,498,900.00	241,878,648.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	467,352,100.00	437,695,625.40
2105	Нормативт зардал	3,133,533,700.00	1,996,960,296.32
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	135,241,800.00	127,220,385.32
210502	Хоол, хүнс	2,767,215,100.00	1,652,752,231.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	231,076,800.00	216,987,680.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	718,392,900.00	454,866,136.65
210601	Багаж, техник, хэрэгсэл	140,850,000.00	118,403,364.00
210602	Тавилга	52,175,000.00	15,951,140.00
210604	Урсгал засвар	525,367,900.00	320,511,632.65
2107	Томилолт, зочны зардал	188,644,700.00	95,011,277.00
210702	Дотоод албан томилолт	188,644,700.00	95,011,277.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	5,564,047,700.00	4,566,437,593.34
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйл	5,446,699,500.00	4,458,903,555.34
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	18,239,200.00	15,844,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	5,177,100.00	3,667,779.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,613,000.00	3,964,159.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	2,613,400.00	1,203,640.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	9,478,800.00	9,341,600.00
210807	Газрын төлбөр	77,206,700.00	73,492,560.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний х	20,000.00	20,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,018,801,500.00	18,919,078,249.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,474,904,600.00	18,405,605,278.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	543,896,900.00	513,472,971.00

Өмнөговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

212	ТАТААС	180,000,000.00	145,929,000.00
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	180,000,000.00	145,929,000.00
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	180,000,000.00	145,929,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	53,376,356,700.00	37,688,861,366.20
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	51,787,543,200.00	36,353,542,600.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	51,787,543,200.00	36,353,542,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,588,813,500.00	1,335,318,766.20
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	41,000,000.00	21,960,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	650,914,100.00	494,069,825.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэ	401,655,400.00	368,181,988.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	500,000.00	488,889.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	494,744,000.00	450,618,064.20
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	101,770,909,400.00	89,170,068,956.77
2200	Дотоод эх үүсвэрээр	101,770,909,400.00	89,170,068,956.77
222001	Тоног төхөөрөмж	41,785,200.00	41,785,170.00
223001	Бусад хөрөнгө	101,729,124,200.00	89,128,283,786.77
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	236,076,214,300.00	204,376,196,083.05
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	49,457,778,300.00	46,799,538,730.98
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	35,269,314,400.00	32,858,192,949.98
131008	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүү	14,188,463,900.00	13,941,345,781.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	172,546,694,100.00	155,314,901,171.63
132001	Орон нутгийн төсвөөс	172,546,694,100.00	155,314,901,171.63
1340	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС С	251,147,400.00	201,562,741.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	251,147,400.00	201,562,741.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ	13,820,594,500.00	2,060,193,439.44
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	157,010,400.00	99,062,815.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	6,027,808,700.00	1,961,130,624.44
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	7,635,775,400.00	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		4,964,074,142.26
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		8,653,827,702.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	121	121
610001	Төсвийн байгууллага	121	121
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	3,116	2,961
620001	Удирдах ажилтан	212	209
620002	Гүйцэтгэх ажилтан	1,877	1,780
620003	Үйлчлэх ажилтан	978	920
620004	Гэрээт ажилтан	49	52
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)	19,136	18,923
630	ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРА	13,451	13,431
630001	Төрийн өмчит ЕБС	13,451	13,431
631	СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГ	5,685	5,492
631001	Төрийн өмчит СӨБ байгууллага	5,685	5,492
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	2,372	2,813
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо	2,372	2,813

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	25,755,211,841.49	28,589,493,309.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,094,337,238.49	25,886,539,998.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	20,996,672,544.46	24,541,775,879.22
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	539,707,549.32	345,613,232.52
210101	Үндсэн цалин	518,090,451.32	125,172,563.52
210102	Нэмэгдэл	3,290,686.00	4,536,914.00
210105	Гэрээт ажлын хөлс	18,326,412.00	215,903,755.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,177,542.14	39,857,209.16
210201	Тэтгэврийн даатгал	35,837,781.83	34,163,515.16
210202	Тэтгэмжийн даатгал	776,730.57	315,831.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	150,141.27	2,983,655.40
210204	Ажилгүйдлийн даатгал	37,535.32	124,951.34
210205	Эрүүл мэндийн даатгал	375,353.15	2,269,255.51
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13,553,096.00	10,225,064.00
210301	Гэрэл, цахилгаан		41,284.00
210302	Түлш, халаалт	577,616.00	1,025,650.00
210303	Цэвэр, бохир ус		1,035,240.00
210304	Байрны түрээс	12,975,480.00	8,122,890.00
2104	Хангамж, бараа материалын зардал	256,681,600.00	305,813,191.00
210401	Бичиг хэрэг	27,428,999.00	29,846,190.00
210402	Тээвэр, шатахуун	176,176,141.00	165,170,016.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,699,600.00	5,207,520.00
210404	Ном, хэвлэл	16,438,550.00	35,760,760.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	33,303,510.00	69,828,705.00
2105	Нормативт зардал	74,155,790.00	129,236,884.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,808,470.00	15,417,780.00
210502	Хоол, хүнс	62,605,680.00	101,810,084.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдтэл	9,741,640.00	12,009,020.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	139,479,851.00	305,027,373.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,977,000.00	111,773,600.00
210602	Тавилга	3,650,000.00	10,929,895.00
210604	Урсгал засвар	124,852,851.00	182,323,878.00
2107	Томилолт, зочны зардал	56,270,200.00	65,498,112.00
210702	Дотоод албан томилолт	56,270,200.00	65,498,112.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	484,246,331.00	934,469,152.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	481,040,331.00	933,363,767.00
210803	Даатгалын үйлчилгээ	256,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар		196,385.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		30,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,950,000.00	879,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	19,395,400,585.00	22,406,035,661.54
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,033,973,039.00	22,241,688,476.54
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	361,427,546.00	164,347,185.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,097,664,694.03	1,344,764,119.23
2132	Бусад урсгал шилжүүлэг	702,927,998.00	1,058,962,821.91
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж		2,160,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	702,927,998.00	1,056,802,821.91
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	394,736,696.03	285,801,297.32
213403	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг	394,736,696.03	285,801,297.32

22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,660,874,603.00	2,702,953,311.22
2200	Дотоод эх үүсвэрээр	3,660,874,603.00	2,702,953,311.22
223001	Бусад хөрөнгө	1,567,639,238.00	721,946,241.00
225001	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,093,235,365.00	1,981,007,070.22
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	25,755,211,841.49	28,589,493,309.67
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	25,755,211,841.49	28,589,493,309.67
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	611,743,457.00	215,014,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	22,526,328,944.00	25,078,309,855.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	879,512,857.00	1,219,066,310.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	1,737,626,583.49	2,077,103,144.67

3. Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Өмнөговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, жилийн төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг төсвийн ерөнхийлөн захирагч Р.Сэддорж танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 04 дүгээр сарын 01-ээс 2021 оны 04 дүгээр сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Өмнөговь аймаг дахь төрийн аудитын газрын аудитын менежер Т.Хонгорзул хянан удирдаж, ахлах аудитор Ж.Болормаа, аудитор Д.Сүрэнжаргал, С.Одончимэг нар гүйцэтгэв.

Өмнөговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 1-975 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Өмнөговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Төрийн үйлчилгээнд олон улсын менежментийн тогтолцоог нэвтрүүлж, иргэн төвтэй хариуцлагатай манлайлагч байгууллага байна” гэж тодорхойлсон байна.

Дээрх эрхэм зорилгынхоо хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны стратегийн зорилтыг хэрэгжүүлэхээр тодорхойлсон байна. Үүнд:

- Төрийн үйлчилгээний ил тод, шуурхай байдлыг тэргүүн туршлага болгоно.
- Бодлого төлөвлөлт, бодлогын хэрэгжилтийн үр дүнг сайжруулах тэргүүний туршлагыг нэвтрүүлнэ.
- Иргэд, талуудтай зөвлөлдөх, тэдний үнэлгээ, санаа бодлыг тусгах зарчмыг үйл ажиллагаанд хэвшүүлнэ.
- Төрийн албаны мэргэшсэн, чадварлаг, тогтвортой байх нөхцөлийг ТАЗСЗ-тэй хамтран бүрдүүлнэ.
- Төрийн албан дахь хариуцлагыг сайжруулах цогц арга хэмжээ хэрэгжүүлнэ.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Өмнөговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь санхүүгийн нэгтгэсэн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Өмнөговь аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, аудитын алба нь 2020 онд төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа 186 байгууллагад эрсдэлийн үнэлгээ хийж, тус онд 97 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт, 1 байгууллагад дотоод аудит хийхээр төлөвлөж, бүрэн хамруулан ажилласан байна. Тайлант онд хийсэн санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитаар санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр нийт 1,003.5 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж, 172.8 сая төгрөгийг төсвийн орлогод, 830.7 сая төгрөгийг тухайн байгууллагад төвлөрүүлэхээр 227 төлбөрийн акт, 85.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах 7 албан шаардлага хүргүүлсэн байна. Тогтоосон төлбөрийн акт 98.8 хувьтай, албан шаардлага 100 хувьтай хэрэгжсэн байна.

3.4 Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлаас сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт зардлын 278,140.6 сая төгрөгийн 1 хувь буюу 2,781.4 сая төгрөгөөр тогтоов.

Гүйцэтгэлийн үе шатанд төлөвлөлтийн шатанд тогтоосон материаллаг байдлын түвшнийг өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.5 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн үзүүлэлт

3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 118,049.1 сая, эцсийн үлдэгдэл 132,952.8 сая төгрөг болж, 14,903.7 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №1. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Дүнд эзлэх хувь
Касст байгаа бэлэн мөнгө	10.3	13.5	3.2	0.01
Банканд байгаа бэлэн мөнгө	116,038.1	132,928.3	16,890.2	99.9
Замд яваа мөнгөн хөрөнгө	0.1	0.4	0.3	
Хадгаламж	2,000.6	10.6	-1,990.0	0.09
Дүн	118,049.1	132,952.8	14,903.7	100

Эх сурвалж: Өмнөговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 24.5 сая төгрөг төрийн сангийн урсгал санхүүжилтийн харилцах дансанд, 98.6 сая төгрөг арилжааны банкны дансанд, 9.9 сая төгрөг бусад төсөл, нөөцийн харилцах дансанд байршиж байна.

Замд яваа мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд Гүний ус ХХК-ны постын машины 0.4 сая төгрөгийн мөнгөн хөрөнгө байна.

Хадгаламж дансанд Гүний ус ХХК-ны 10.6 сая төгрөгийн хадгаламж байгаа ба хадгаламж данс нээх ТУЗ-ийн шийдвэргүй байна.

Аудитын илрүүлэлт:

- Булган сумын ЗДТГазар нөөц сангаас 3.8 сая төгрөгийг кассын зарлагын анхан шатны баримтын бүрдэлгүй бэлэн мөнгө олгосон, зөвшөөрөгдөөгүй зардлууд бэлэн мөнгөний дансаар зарцуулсан,
- Аймгийн ИТХурал шатахуун, хэвлэлийн зардал, сургалтын зардал болон бусад арга хэмжээний зардлуудын 6.5 сая төгрөгийг бэлэн мөнгөний дансаар зарцуулсан,

- Ханбогд сумын ЗДТГ нь нүүрс тээврийн замын засвар үйлчилгээг хариуцдаг Гашуун сухайт Авто зам ХХК -аас байгаль орчны сургалтад зориулж 5.0 сая төгрөгийн хандив авч зарцуулсан,
- Ханбогд сумын ЗДТГазар нь БҮТЭЗ-аас 0.7 сая төгрөгийн интернэтийн төлбөр, бичиг хэргийн зардлаас 0.3 сая төгрөгийн компьютерын засварын үнэ, шуудан холбооны зардлаас 1.7 сая төгрөгийн компьютерын засварын үнэ төлсөн байна.

3.5.2 Авлага

Авлага дансны эхний үлдэгдэл 40,951.1 сая, эцсийн үлдэгдэл 29,331.5 сая төгрөг болж, 11,619.6 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №2 Авлагын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	149.9	122.7	-27.2
Төлбөртэй үйлчилгээний авлага	115.4	49.5	-65.9
Зээлийн хүүгийн авлага	58.3	61.1	2.8
Дансны авлага	27,892.6	17,046.8	-10,845.8
Бусад авлага	12,544.2	11,869.3	674.9
Зээлийн авлага	190.7	182.1	-8.6
Дүн	40,951.1	29,331.5	-11,619.6

Эх сурвалж: Өмнөговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үүссэн нийт авлагаас 8,692.3 сая төгрөг буюу 29.6 хувийг төвийн байгууллага, 17,526.5 сая төгрөг буюу 59.7 хувийг ОНӨААН, 3,062.3 сая төгрөг буюу 10.4 хувийг төсөл сан, 50.4 сая төгрөг буюу 0.3 хувийг төрийн сангийн авлага байна.

Авлагын үлдэгдлийн насжилт дараах байдалтай байна.

№	Данс	Үлдэгдэл дүн /сая. төг/	Авлагын насжилт		
			1 жил хүртэл	1-5 жил	5 жилээс дээш
A	АВЛАГЫН ДҮН	29,331.50	8,704.90	12,220.30	8,406.30
1	Ажиллагсадтай холбоотой авлага	122.70	88.20	22.50	12.00
1.1	Төсөв байгууллага	35.70	8.90	20.00	6.80
1.2	ОНӨААН	87.00	79.30	2.50	5.20
2	Дансны авлага	16,465.70	7,558.60	8,883.10	23.90
2.1	ОНӨААН	16,465.70	7,558.60	8,883.10	23.90
3	Татвар НДШ-ын авлага	630.20	627.00	2.00	1.20
3.1	ОНӨААН	630.20	627.00	2.00	1.20
4	Байгууллагаас авах авлага	9,011.60	425.30	2,563.10	6,023.20
4.1	Төсөв байгууллага	8,656.60	249.90	2,463.20	5,943.40
4.2	ОНӨААН	304.00	175.40	99.90	28.80
4.3	Төсөл сан	0.70			0.70
4.4	Төрийн сан	50.30			50.30
5.1	Хувь хүмүүсээс авах авлага	3,101.30	5.80	749.60	2,346.00
5.1	ОНӨААН	39.70	5.80	26.90	7.10
5.2	Төсөл сан	3,061.60		722.70	2,338.90

Төсөвт байгууллагын авлагын үлдэгдэл дараах авлага байна. Үүнд: 35.7 сая төгрөг ажиллагсадтай холбоотой авлага, 4.7 сая төгрөг, төлбөрт үйлчилгээний авлага, 61.0 сая төгрөг зээлийн хүүгийн авлага, 8,590.9 сая төгрөг байна.

Мөн ОНӨОААН болон ОНӨААТҮГ-ын авлагын үлдэгдэл дараах авлага байна. Үүнд: 87.0 сая төгрөг ажиллагсадтай холбоотой авлага, 16,467.7 сая төгрөг дансны авлага, 630.2 сая төгрөгийн татвар, НДШ-ын авлага, 304.0 сая төгрөгийн байгууллагаас авах авлага байна.

5 жилээс дээш насжилттай 8,406.3 сая төгрөгийн авлагын үлдэгдэлд 1995-2002 онд газар тариалан эрхлэх, өвс тэжээлийн нөөц бэлтгэх, эрчим хүчний тооцооны авлага, 2013 оноос хойш олгосон сум хөгжүүлэх сангийн зээлийн авлагууд, 2000-2011 онд ЖДҮДС, 2013-2014 онд үүссэн орон сууцны сангийн зээл болон өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхэд үүссэн авлагууд нь олон жилийн насжилттай байгаа нь төсвийн хөрөнгийн үнэгүйдүүлэх, үр ашиггүй зарцуулах, эзэн холбогдогч тодорхойгүй болох үр дагавартай байна.

Аудитын илрүүлэлт:

- Даланзадгад сумын ЗДТГазар 37.1 сая төгрөг, Манлай сумын Соёлын төв 6.5 сая, ЕБС 1.2 сая төгрөг, Булган сумын ЕБС 6.5 сая төгрөг, Буянт хотхон УТҮГ 2.5 сая төгрөг, Сэврэй сумын ЕБС 1.5 сая төгрөгийн авлага үүсгэсэн,
- Цогтцэций сумын ЗДТГазар нэмэлт санхүүжилтийн данснаас санхүү хяналт, аудитын албаны актын төлбөр 1,793.2 мянган төгрөгийг шилжүүлэн авлагын дансанд тусгаагүй,
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа ОНӨОААН, ОНӨААТҮГ-ууд нь тайлант онд дансны авлага 16,416.6 сая төгрөг, татвар, НДШ-ийн авлага 630.2 сая төгрөг, ажиллагсадтай холбоотой, байгууллага, хувь хүмүүс болон төлбөртэй үйлчилгээний авлагын 479.6 сая төгрөг нийт 17,526.4 сая төгрөгийн авлага үүсгэсэн байна.

3.5.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эхний үлдэгдэл 1,435.0 сая, эцсийн үлдэгдэл 2,420.1 сая төгрөг болж, 985.1 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №3 Урьдчилгаа дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	1,406.1	2,411.4	1,005.3
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	6.0	0.0	-6.0
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	14.3	0.0	-14.3
Цалингийн урьдчилгаа	8.6	8.7	0.1
Дүн	1,435.0	2,420.1	985.1

Эх сурвалж: Өмнөговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд 2,411.4 сая төгрөг буюу 98.2 хувийг урьдчилж гарсан зардал эзэлж байна. Үүнд:

- Ханбогд сумын Ханбогд тохижилт ОНӨААТҮГ 383.3 сая төгрөг
- Таван толгой ХК 1,936.0 сая төгрөг
- Хөгжил хөрөнгө оруулалтын газар 56.6 сая төгрөг

3.5.4 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын эхний үлдэгдэл 434.2 сая, эцсийн үлдэгдэл 7,974.2 сая төгрөг болж, 7,540.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №4 Урт хугацаат хөрөнгө оруулалт дансны үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урт хугацаат ХО-т зам гүүр	434.2	7,974.2	7,540.0
Дүн	434.2	7,974.2	7,540.0

Эх сурвалж: Өмнөговь аймгийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

3.5.5 БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалын эхний үлдэгдэл 26,901.5 сая, эцсийн үлдэгдэл 19,348.7 сая төгрөг болж, 7,552.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт №5 Бараа материалын үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	1,000.4	1,937.5	937.1
Дуусаагүй үйлдвэрлэл	75.0	66.5	-8.5
Бэлэн бүтээгдэхүүн	16,538.8	6,564.1	-9,974.7
Хангамжийн материал	8,846.7	10,407.5	1,560.8
Мал амьтад	440.6	373.1	67.5
Дүн	26,901.5	19,348.7	7,552.7

Эх сурвалж: Өмнөговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Нийт бараа материалыг байгууллагын бүтцээр нь авч үзвэл 9,844.3 сая төгрөг буюу 50.9 хувийг төсөвт байгууллага, 10.6 сая төгрөг буюу 0.05 хувийг төсөл сан, 9,493.8 сая төгрөг буюу 49.05 хувийг төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн бараа материал тус тус эзэлж байна

Бараа материалын эцсийн үлдэгдэлд 128,7 сая төгрөгийн хүнсний бараа материал нөөц байгаа нь ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн байгууллагуудад хоол хүнсний материалын нөөцлөлт эзэлж байна. Ковид цар тахлын дэгдэлтэй холбоотойгоор улсын хэмжээнд сургууль, цэцэрлэгийн ажиллагаа хэвийн ажиллахгүйгээс шалтгаалан хүнсний материалын нөөцүүдийн хугацаа дуусаж эрүүл ахуй, үндсэн шимт бодис, илчлэгийн хэмжээ, нормын шаардлагыг хангахгүй болох үр дагавартай байна.

Аудитын илрүүлэлт:

- Манлай сумын ИТХурал 1.9 сая төгрөг, ЗДТГазар 79.5 сая төгрөг, Даланзадгад сумын ИТХурал 8.6 сая төгрөг, Номгон сумын ЗДТГазар 46.9 сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийн тооллого хийж тооцоо бодоогүй,
- Тайлан тооцоог гаргахдаа /Мандал-Овоо сумын ЗДТГ, Соёлын төв Сээрэй сумын Соёлын төв, Ханбогд сумын ЕБ-ийн 1 дүгээр сургууль, Баяндалай сумын ЕБС, Ноён сумын ИТХ, ЗДТГ, ЕБС, Ханхонгор сумын ЗДТГ, ЕБС, Номгон сумын ЗДТГ / анхан шатны баримтын бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн,
- Ханхонгор сумын Соёлын төв 4.7 сая төгрөгийн бараа материалын тайланг гаргаагүй,
- Жолоочийн тооцооны хуудсыг бүрэн хөтлөөгүй, спидометрийн заалт бичээгүй, автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын нормыг мөрдөж ажиллаагүй, тооцоог нэгтгэж хянаагүй нийтлэг зөрчил илэрсэн.

3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн эхний үлдэгдэл 489,015.5 сая, эцсийн үлдэгдэл 547,015.3 сая төгрөг болж, 57,999.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №6 Үндсэн хөрөнгийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	220,142.8	253,406.7	33,263.9
Авто-тээврийн хэрэгсэл	11,422.8	12,233.0	810.2
Машин тоног төхөөрөмж	23,370.0	28,263.1	4,893.1
Тавилга, аж ахуйн эд хогшил	6,967.9	7,869.2	901.3
Зам, гүүрийн байгууламж	114,482.2	121,972.2	7,490.0
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	1,357.8	1,401.4	43.6

Бусад үндсэн хөрөнгө	44,986.5	56,027.0	11,040.5
Дуусаагүй барилга, байгууламж	4,861.4	4,482.8	-378.6
Ном	976.4	1,076.0	99.6
Программ хангамж	1,973.9	1,887.7	-86.2
Бусад биет бус хөрөнгө	58,385.7	58,385.3	-0.4
Бусад эргэлтийн бус хөрөнгө	88.1	10.9	-77.0
/ТӨҮГ/			
Дүн	489,015.5	547,015.3	57,999.8

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгө төсвийн хөрөнгөөр бэлтгэсэн 3,584.9 сая, балансаас баланст шилжүүлсэн 5,387.9 сая төгрөг, үнэ төлбөргүй хандиваар авсан 27,409.9 сая төгрөгөөр нэмэгдсэн, худалдан зарцуулсан 4,080.9 сая төгрөг, балансаас баланст шилжүүлсэн 5,315.5 сая, акталсан 5,151.1 сая төгрөгөөр хасагдсан байна.

Дуусаагүй барилга дансанд байгаа 2011 онд Даланзадгад суманд баригдаж эхэлсэн улсын Соёл, спортын цогцолборын барилга 3,966.5 сая төгрөг, Хүрмэн сумын хүн эмнэлгийн барилга 270.3 сая төгрөг, 2015 он хийгдэж эхэлсэн Мандал-Овоо сумын ЗДТГ Өтгөн багийн өндөр хүчдэлийн шугам 48.9 сая төгрөгийг улсын комиссын актаар хүлээн аваагүй зэрэг шалтгаантайгаар бүртгэлтэй байна.

Аудитын илрүүлэлт:

- Ханбогд сумын ЕБС-ийн 1 дүгээр сургууль, соёлын төв, Ноён сумын ИТХ, ЗДТГ-ууд тооллого тооцоог бүрэн хийгээгүй,
- Аймаг сумын хөрөнгө оруулалт болон ОНХС-аар нийлүүлсэн хөрөнгийг Манлай сумын ЗДТГазар 10.0 сая төгрөг, Даланзадгад сумын ЗДТГазар 9.0 сая төгрөг, Буянт хотхон УТҮГ 9.9 сая төгрөгийн зураг төсөв, Ханбогд сумын ЗДТГазар 197.6 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй,
- Санхүү хяналт аудитын алба, ГБХЗХГазар, Мандал-Овоо сумын Соёлын төв, ЕБС, Хүрмэн сумын Соёлын төвүүд үлдэх өртөггүй тавилга, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл санхүүгийн программ зэрэг хөрөнгөнд бүртгэлтэй,
- Ноён сумын ЕБС иргэдээс 40 мал хандиваар хүлээн авсан боловч данс бүртгэлд тусгаагүй байна.

3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн эхний үлдэгдэл 104,442.0 сая, эцсийн үлдэгдэл 145,713.8 сая төгрөг болж, 41,271.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт №7 Нийт өр төлбөрийн үлдэгдэл /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өссөн+ Буурсан -	Дүнд эзлэх хувь
Богино хугацаат өр төлбөр дүн	67,467.7	86,372.4	18,904.7	59.3
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	688.6	755.4	66.8	0.5
Ажилчидтай холбогдсон өглөг	633.5	137.2	-496.3	0.09
Бараа үйлчилгээний зардлын өглөг	40.4	15.7	-24.7	0.01
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	20,764.6	20,391.1	-373.5	14.0
Зээлийн хүүгийн өглөг	744.5	744.5	0.0	
Бусад өглөг	19,014.8	41,151.6	22,136.8	28.2
Урьдчилж орсон орлого	25,581.3	23,176.9	-2,404.4	16.5
Урт хугацаат өр төлбөр дүн	36,974.3	59,341.4	22,367.1	40.7
Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	500.7	7,973.9	7,473.2	5.5

Хойшлогдсон татварын өр /ТӨҮГ/	35,842.6	51,343.7	15,501.1	35.2
Бусад өр төлбөр /ТӨҮГ/	451.0	23.8	-427.2	0.0
Нийт дүн	104,442.0	145,713.8	41,271.8	100

Эх сурвалж: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 20,297.5 сая төгрөгийн хөрөнгө оруулалтын дуусаагүй ажил, 8,298.5 сая төгрөгийн барьцаа, Орон нутгийн өмчит үйлдвэрийн газруудын УОО, татвар, нийгмийн даатгал, ногдол ашиг, болон бусад 57,020.8 сая төгрөгийн өглөг, Гүний ус ХХК-ийн зээлийн хүүгийн 755.5 сая төгрөгийн, /2004 онд хэрэгжсэн Азийн хөгжлийн банкны нийтийн аж ахуйн төсөл 1,101.2 сая төгрөгийн зээл/ зээлийн хүүгийн өр байна.

Богино хугацаат өр төлбөрийн 21,172.1 сая төгрөг буюу 24.5 хувийг төсөвт байгууллага, 9,449.5 сая төгрөг буюу 10.9 хувийг тусгай зориулалтын сан, 55,750.7 сая төгрөг буюу 64.6 хувийг ОНӨҮГ-ууд эзэлж байна.

Урт хугацаат өр төлбөрийн үлдэгдэлд 51,343.7 сая төгрөгийн ОНӨААТҮГ-удын хойшлогдсон өр төлбөр /СТОУС 20-ын дагуу/, 7,973.9 сая төгрөгийн гадаад зээлээс дамжуулан зээлдүүлсэн /Зүүн өмнөд говийн бүсийн хот байгуулалт, хилийн ойролцоо суурин газруудын хөгжлийн төсөл хүрээнд тус аймагт цэвэрлэх байгууламж барих ажил/, 23.8 сая төгрөгийн бусад өр төлбөрөөс үүссэн өр байна.

Аудитын илрүүлэлт:

- Даланзадгад сумын ЗДТГазар 37.2 сая төгрөг, Буянт хотхон УТҮГ 12.8 сая төгрөгийн өглөг,
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа ОНӨОААН, ОНӨААТҮГ-ууд нь тайлант онд дансны өглөг 13,247.1 сая төгрөг, татварын өглөг 24,924.3 сая төгрөг, ногдол ашгийн өглөг 11,990.1 сая төгрөг, бусад хөрөнгө бэлтгэхтэй холбоотой өглөг, зээлийн хүү, ажиллагсад, байгууллага, хувь хүмүүстэй холбоотой 1,276.4 сая төгрөг нийт 51,437.9 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөр үлдэгдэлтэй байна.

3.5.8 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эхний үлдэгдэл 617,419.7 сая, эцсийн үлдэгдэл 657,109.6 сая төгрөг болж, 39,689.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Засгийн газрын хувь оролцоо /сая төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт/+, бууралт -/	Дүнд эзлэх хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	157,525.3	167,292.3	9,767.0	25.4
Хуримтлагдсан үр дүн	431,576.2	462,051.4	30,475.2	70.3
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	28,318.2	27,765.9	-552.3	4.3
Дүн	617,419.7	657,109.6	39,689.9	100.0

Эх сурвалж: Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 657,109.6 сая төгрөг болж 39,689.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалжээ. Үүнд:

- Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 27,765.9 сая төгрөг болж 552.3 сая төгрөгөөр буурсан нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөс шалтгаалжээ.
- Хуримтлагдсан үр дүн 462,051.4 сая төгрөг болж 30,475.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалжээ.

Аудитын илрүүлэлт:

- ОНӨААҮГ-ууд улсын бүртгэлийн гэрчилгээнд өмчид орсон өөрчлөлтийг тухай бүр тусгаж өгөөгүй нийтлэг зөрчил илэрсэн.

3.5.9 Орлогын данс

Төсөвт байгууллагын өөрийн орлогоор тус онд 6,184.8 сая төгрөг төлөвлөхөөр батлагдсанаас гүйцэтгэлээр 2,060.0 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, өөрийн орлогын төлөвлөгөөг 33.3 хувиар биелүүлж, 4,124.8 сая төгрөгийг тасалсан байна.

3.5.10 Зардлын данс

Зардлын данстай холбоотой 1,996.4 сая төгрөгийн зөрчил илэрлээ. Тухайлбал: төсвийг үр ашиггүй зориулалт бусаар зарцуулсан 322.3 сая төгрөг, хууль зөрчин ИТХ-аар батлуулж зарцуулсан 188.0 сая төгрөг, барьцаа дансанд байршуулаагүй 220.5 сая төгрөг, гэрээний дүнгээс илүү байршуулсан 140.7 сая төгрөг, гэрээнд барьцаалах нөхцөлийг зааж өгөөгүй 728.9 сая төгрөг, нэмэлт гэрээг хуулийн дагуу зохион байгуулаагүй 179.4 сая төгрөг, иргэдийн санал аваагүй батлуулж зарцуулсан 126.0 сая төгрөг, төсөл арга хэмжээг ажлын даалгаваргүй зарцуулсан 90.6 сая төгрөг байна.

Аудитын илрүүлэлт:

- Булган сумын ЕБСургууль эрхзүйн шийдвэр үндэслэлгүй, анхан шатны баримт цагийн бүртгэл хөтлөөгүй илүү цагийн нэмэгдэл хөлсөнд 7.3 сая төгрөг олгосон,
- Ханбогд сумын ЕБС-ийн 2 дугаар сургууль хавтгайруулан 5.0 сая төгрөгийн илүү цаг тооцож олгосон,
- Ноён сумын ЕБСургууль цалингийн зардлаас 3.4 сая төгрөгийг орон тооны бус гэрээт авч цалинжуулсан,
- ХЖТеатр, Манлай сумын ЗДТГазар, Цогт-Овоо сумын ЕБСургууль, Даланзадгад сумын ИТХурал, ЗДТГазар, 1,2,3 дугаар сургууль, төвийн бүх цэцэрлэгүүд түлээ нүүрсний үнийг бүх ажилчдад хавтгайруулан олгосон,
- Ханхонгор сумын ЗДТГазар цалингийн зардлаас иргэний холбогдолтой шүүхийн шийдвэрийг буруу хэрэгжүүлж 8.9 сая төгрөгийг зарцуулсан,
- Сэврэй сумын ЕБС шууд гэрээгээр 15.0 сая төгрөг зарцуулсан,
- БСУГазар нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас 2.8 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл, тавилгын зардлыг зориулалт бусаар зарцуулсан,
- Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс Гурвантэс сум 4.2 сая төгрөг, Даланзадгад сум 49.9 сая төгрөг, Булган сум 20.8 сая төгрөг, Мандал-Овоо сум 16.5 сая төгрөг, Сэврэй сум 33.6 сая төгрөг, Ханбогд сум 19.8 сая төгрөг, Цогт-Овоо сум 5.6 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан,
- Мөн Баян-Овоо сум 17.8 сая төгрөг, Цогтцэций сум 10.0 сая төгрөгийг зөвлөлийн шийдвэргүй, хүсэлтгүй, Номгон сум өвлийн бэлтгэл хангах зардалд 10.0 сая төгрөгийг хэнд өгсөн нь тодорхой эзэнгүй, Ноён сум 14.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэхэд зориулалт бусаар зарцуулсан,
- Гурвантэс сум 75.8 сая төгрөгийг хүчингүй болсон Сангийн сайдын 2012 оны 239 дугаар тушаалын заалтаар захиран зарцуулсан,

- Аймгийн ИТХ-ын 2019 оны 9/6, 2020 оны 2/7 дугаар тогтоолоор бүх шатны иргэдийн төлөөлөгчдийн хурал нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 211.1 сая төгрөгийг өөрийн төсөвтөө батлуулж, 188.0 сая төгрөгийг зарцуулсан,
- Орон нутгийн хөгжлийн сангаас: Баяндалай сум 6.5 сая төгрөг, Сэврэй сум 83.1 сая төгрөг, Цогт-Овоо сум 22.4 сая төгрөг, Ханбогд сум 108.5 сая төгрөгийн ажлуудаас барьцаа хөрөнгө суутгаж байршуулаагүй,
- Манлай сум ЭМТ-ийг тоног төхөөрөмжөөр хангах ажлын үлдэгдэл 29.5 сая төгрөг, Даланзадгад сумын ЗДТГ хөрөнгө оруулалтаар хийгдсэн 3 ажлын гэрээний дүнгээс илүү 111.2 сая төгрөгийг барьцаа дансанд байршуулсан,
- Баян-Овоо сум 728.9 сая төгрөгийн 2 ажилд барьцаалах нөхцөлийг гэрээнд тусгаж өгөөгүй,
- Цогтцэций сум ОНХС-аас 19.6 сая төгрөг, Номгон сум ОНХС-аас 26.5 сая төгрөгийн урсгал зардлыг санхүүжүүлсэн,
- Даланзадгад сум орон нутгийн хөрөнгө оруулалтаар гүйцэтгэсэн ажилд 5.5 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулах шалтгааныг тодорхойлсон тухай нотлох баримт материал байхгүй,
- Сэврэй сум ОНХС-аас хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээнд иргэд олон нийтээс санал аваагүй 36.0 сая төгрөгийн 2 ажил, Цогт-Овоо сум 90.0 сая төгрөгийн 2 ажлыг ИТХ-аар батлуулж, санхүүжүүлсэн байна.

3.6 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Өмнөговь аймгийн ИТХ-ын 2020 оны “Орон нутгийн төсвийн тодотголын тухай” 2/7 дугаар тогтоол болон сумдын ИТХ-ын “Төсвийн тодотгол батлах тухай” тогтоолд зааснаар тайлант онд 138,721.3 сая төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 128,935.6 сая төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 92.9 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Б	1	2	3	4=3-2	5
УРСГАЛ ОРЛОГО	135,630.9	138,721.2	128,935.6	(9,785.6)	92.9
Татварын орлого	104,460.7	107,504.7	112,166.9	4,662.2	104.3
Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын	46,846.2	44,000.0	45,184.2	1,184.2	102.7
Үйл ажиллагааны орлогын албан татвар	1,051.7	2,776.6	2,417.7	(358.9)	87.1
Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч хувь хүний ОАТ	936.7	818.4	1,924.6	1,106.2	235.2
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	(916.9)	(844.8)	(844.8)	-	100.0
Үл хөдлөх хөрөнгийн татвар	24,266.9	26,400.0	27,830.5	1,430.5	105.4
Бууны албан татвар	51.9	34.5	36.3	1.8	105.2
Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	4,204.1	4,300.0	6,670.8	2,370.8	155.1
Улсын тэмдэгтийн хураамж	611.4	347.7	418.1	70.4	120.2
Газрын төлбөр	5,709.3	8,675.9	7,743.6	(932.3)	89.3
Дуудлага худалдаа сонгон шалгаруулалт	327.7	560.0	2,082.3	1,522.3	371.8
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	164.5			-	
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	18,454.9	18,057.1	16,315.0	(1,742.1)	90.4
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	2,001.2	1,302.4	1,239.5	(62.9)	95.2
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	304.2	434.6	473.1	38.5	108.9
Газрын тосны орлого	118.6	102.9	8.4	(94.5)	8.2
Бусад татвар хураамж	81.0	200.0	236.0	36.0	118.0
Хөрөнгө борлуулсны орлого	247.3	339.4	431.6	92.2	127.2
Татварын бус орлого	31,170.2	31,216.5	16,768.7	(14,447.8)	53.7
Хувьцааны ногдол ашиг	23,001.6	20,629.6	10,502.4	(10,127.2)	50.9
Түрээсийн орлого	57.6	25.0	39.2	14.2	156.8
Төсөвт байгууллагын өөрийн орлого	2,393.5	6,184.8	2,060.2	(4,124.6)	33.3
Хүү, торгуулийн орлого	4,906.0	3,484.5	3,184.6	(299.9)	91.4
Бусад орлого	811.5	892.6	982.3	89.7	110.0

Орон нутгийн төсвийн орлого 9,785.6 сая төгрөгөөр тасарсан шалтгааныг шалгагдагч байгууллагаас тодруулахад “Коронавируст халдвар КОВИД-19 цар тахлын улмаас Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн 178 дугаар тогтоолоор бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж, улмаар 2020 оныг дуустал хөл хорио тогтоосон шат дараалсан арга хэмжээнүүдийг авч улс, аймаг, сумдын хоорондох иргэдийн зорчих хөдөлгөөнийг хязгаарласнаас шалтгаалан Таван толгой ЖК-ны ногдол ашгийн орлого тасарсан” гэсэн тайлбарыг ирүүлсэн.

Энэ нь төсвийн орлогыг цаг хугацаанд нь шилжүүлэхгүй байх үндэслэл болохгүй бөгөөд Таван толгой ХК нь 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 95,945.7 сая төгрөгийн харилцахын үлдэгдэлтэй байсан.

Татварын орлогын хувьд Өмнөговь аймгийн Татварын хэлтсээс орлогын төлөвлөгөө нэр төрлөөр тасалсан шалтгааныг 2021 оны 04-р сарын 14-ний өдрийн 1/230 албан бичгээр дараах байдлаар ирүүлсэн байна.

- Хувь хүний орлогын албан татвар нь корона вирусын дэгдэлттэй холбоотойгоор бизнес эрхлэгчдийн үйл ажиллагааг хөл хорионы улмаас зогсоож байсантай холбоотойгоор иргэдийн татварын төлөлт эрс багасаж татварын орлогын төлөвлөгөө тасрахад гол нөлөө үзүүлсэн.
- Аймгийн ЗДТГ-аас ТТАМ ашиглах зөвшөөрөл олгодог боловч эргээд хэдий хэмжээний ТТАМ ашигласан талаарх мэдээлэл байхгүй учир татварыг хураах боломжгүй,
- Газрын төлбөрийн төлөвлөгөө хэт өндөр төлөвлөгдсөн бөгөөд Оюу толгой ХХК-аас 2019 онд 1,300.0 сая төгрөг илүү төлсөн гэж суутган тооцуулснаас орлогын төлөвлөгөө тасарсан,
- БОАЖГ-аас усны дүгнэлт цаг хугацаандаа гардаггүй, гол субъект болох Оюу толгой ХХК-ны ус ашиглалтад эрх бүхий байгууллага хяналтаа тавьж ногдуулалт хийдэггүй, татварын албаны хувьд тухайн татвар төлөгчийн тайлагнасан татварын өрийг хураан барагдуулдаг.

Татварын бус орлогын хувьд Таван толгой ХК-ний хувьцааны ногдол ашгийн 11,321.2 сая төгрөгийг тухайн компани шилжүүлээгүйгээс ондоо багтаж төвлөрөөгүй, төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө тасарсан нь 2013, 2014 онд “1000 айлын орон сууц хөтөлбөр”-ийн хүрээнд олгосон эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн авлага төлөгдөөгүйтэй холбоотой байна.

Төсвийн төлөвлөлт

Сангийн яамнаас аймгийн нийт орлого, зарлагын дүнг 145,151.9 сая төгрөгөөр хянасан бөгөөд Өмнөговь аймгийн ИТХ-ын 2019 оны “2020 төсвийн тухай” 9/6 дугаар тогтоол болон сумдын ИТХ-ын “2020 оны төсвийн тухай” тогтоолд зааснаар тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн 2020 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 254,864.5 сая төгрөгөөр, нийт зарлагыг 254,864.5 сая төгрөгөөр тооцон төлөвлөж баталсан байна.

Оны эцэст Төсвийн тухай хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1.2-д заасан бүрэн эрхийн хүрээнд Өмнөговь аймгийн ИТХ 2020 оны “Орон нутгийн төсвийн тодотголын тухай” 2/7 дугаар тогтоол болон сумдын ИТХ-ын “Төсвийн тодотгол батлах тухай” тогтоолд зааснаар 2020 оны төсвийн зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр, нийт зарлагыг 18,788.3 сая төгрөгөөр бууруулан тодотгон баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 24 хөтөлбөрт зориулан 236,076.2 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 134,305.3 сая төгрөгийг урсгал зардалд, 101,770.9 сая төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 49,457.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 172,546.7 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 251.1 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 13,820.6 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого (өөрийн орлого 6,184.8 сая төгрөг болон шилжих үлдэгдэл 7,635.8 сая төгрөг) -оос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 49,218.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 160,202.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 201.6 сая төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 2,060.2 сая, нийт 211,683.4 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон байна.

Төсөвт байгууллагын үйл ажиллагаа буюу үндсэн болон туслах үйл ажиллагаанаас 2,060.2 сая төгрөг бүрдүүлж, батлагдсан төсвөөс 4,124.6 сая төгрөгөөр тасарсан нь “1000 айлын орон сууц хөтөлбөр”-ийн хүрээнд олгосон эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн авлага барагдаагүйгээс шалтгаалжээ.

Хүснэгт 3. Төсвийн гүйцэтгэл

/сая төгрөг/

Тайлангийн үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны		Зөрүү +/-	Хувь
		Төлөөлөгөө	Гүйцэтгэл		
Б	1	2	3	4=3-2	5
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	194,267.1	236,076.2	200,686.4	35,389.8	85.0
УРСГАЛ ЗАРДАЛ	115,725.4	134,305.3	111,516.3	22,789.0	83.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	55,845.1	80,748.9	73,681.6	7,067.3	91.2
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	27,867.7	36,368.8	34,898.7	1,470.1	96.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,467.6	5,082.0	4,735.8	346.2	93.2
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,970.5	6,106.8	5,669.3	437.5	92.8
Хангамж, бараа материалын зардал	2,150.2	2,567.9	2,345.4	222.5	91.3
Нормативт зардал	2,234.6	3,133.5	1,997.0	1,136.5	63.7
Эд хогшил, урсгал засварын зардал	1,374.6	718.4	454.9	263.5	63.3
Томилолт, зочны зардал	318.7	188.6	95.0	93.6	50.4
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,128.5	5,564.1	4,566.4	997.7	82.1
Бараа үйлчилгээний бусад зардал	9,332.7	21,018.8	18,919.1	2,099.7	90.0
ТАТААС	472.1	180.0	145.9	34.1	81.1
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	472.1	180.0	145.9	34.1	81.1
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,408.2	53,376.4	37,688.8	15,687.6	70.6
Засгийн газрын урсгал шилжүүлэг	58,300.8	51,787.6	36,353.5	15,434.1	70.2
Бусад урсгал шилжүүлэг	1,107.4	1,588.8	1,335.3	253.5	84.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	77,635.4	101,770.9	89,170.1	12,600.8	87.6
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР	906.3			-	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	190,242.1	236,076.2	204,376.2	31,700.0	86.6
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	33,539.1	49,457.8	46,799.5	2,658.3	94.6
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	27,652.7	35,269.3	32,858.2	2,411.1	93.2
Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	5,886.4	14,188.5	13,941.3	247.2	98.3
ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	154,168.6	172,546.7	155,314.9	17,231.8	90.0
Орон нутгийн төсвөөс	154,168.6	172,546.7	155,314.9	17,231.8	90.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	2,393.5	13,820.6	2,060.2	11,760.4	14.9
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГААС САНХҮҮЖИХ	140.9	251.1	201.6	49.5	80.3
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			4,964.1		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл			8,653.8		

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 200,686.4 сая төгрөг буюу 85.0 хувьтай байгаа нь Коронавируст цар тахлын үед Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай” 114 дугаар тогтоол, мөн “Коронавируст халдвар /COVID-19/ цар тахлын үед төсвийн зохицуулалт хийх зарим арга хэмжээний тухай” 168 дугаар тогтоол, “Төсвийн ерөнхийлөн захирагч нарт зохицуулалтын эрх олгох тухай” 187 дугаар тогтоолууд гарч төсвийн хэмнэлтийн горимд шилжин, төсөвт зохицуулалт хийж ажилласантай холбоотой байна.

Үүнд: Төсвийн урсгал зардлаас бүх шатны төсвийн байгууллагын гадаад, дотоод албан томилолт, нэмэгдэл хөлс, урамшуулал, нормативд зардал, хангамж, бараа материалын зардал, сургалт, семинар зохион байгуулах, тавилга эд хогшил худалдан авах,

урсгал засвар хийх, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал, цалин хөлснөөс бусад бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, бараа үйлчилгээний бусад зардал зэрэг зардлуудыг тус тус хэмнэж, улсын төсөвт 15,434.0 сая төгрөгийн татаасыг орлогын төлөвлөгөө биелээгүйгээс төвлөрүүлээгүй байна.

Урсгал санхүүжилтээс дутуу зарцуулсан тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын 2,419.1 сая төгрөг, газрын албаны төвлөрүүлэх шилжүүлэг 216.7 сая төгрөгийг тус тус улсын төсөвт, орон нутгийн төсвийн байгууллагуудын 4,888.0 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Хөрөнгө оруулалтын 6 төсөл, арга хэмжээнд 101,770.9 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 89,170.1 сая төгрөгийн санхүүжилт олгож хөрөнгийн зардалд 12,600.0 сая төгрөг хэмнэсэн нь хөрөнгө оруулалтын ажлууд тайлант ондоо багтаж хийгдээгүйтэй холбоотой байна.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламжаар 215.0 сая, Засаг даргын нөөц хөрөнгөөс 25,078.3 сая, дээд шатны төсвийн захирагчаас 1,219.1 сая, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,077.1 сая, нийт 28,589.5 сая төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Хүснэгт 4. Нэмэлт төсвийн гүйцэтгэл

/сая төгрөг/

№	Сумдын нэр	Өмнөх оны гүйцэтгэл	2020 он		
			Санхүүжилт	Зарцуулалт	Үлдэгдэл
А	Б	1	2	3	4
1	Баяндалай	1,507.9	1,360.8	1,360.8	-
2	Баян-Овоо	1,028.6	1,213.5	1,213.5	-
3	Булган	1,283.7	1,037.0	1,037.0	-
4	Гурвантэс	1,688.6	1,755.2	1,755.2	-
5	Мандал-Овоо	1,037.0	1,937.8	1,937.8	-
6	Манлай	1,424.0	1,798.8	1,798.8	-
7	Номгон	287.8	925.8	925.8	-
8	Ноён	1,219.5	492.7	492.7	-
9	Сэврэй	1,441.3	1,385.6	1,385.6	-
10	Ханбогд	464.8	1,616.9	1,616.9	-
11	Ханхонгор	1,145.7	427.9	427.9	-
12	Хүрмэн	211.5	221.1	221.1	-
13	Цогт-Овоо	899.4	1,304.2	1,304.2	-
14	Цогтцэций	1,068.7	1,032.8	1,032.8	-
15	Даланзадгад	8,478.7	8,615.6	8,615.6	-
16	Аймгийн төвийн төсвийн байгууллагууд	2,568.0	3,463.8	3,463.8	-
ДҮН		25,755.2	28,589.5	28,589.5	-

Нийт нэмэлт санхүүжилтийн 78.4 хувь буюу 22,406.0 сая төгрөг нь бараа үйлчилгээний зардал буюу ОНТХО, ОНХС-ийн эрх шилжсэн хөрөнгө оруулалтын ажлын санхүүжилт байна.

Мөн төрийн албан хаагчдад олгосон говийн дэмжлэг, мал хамгаалах сангийн мал эмнэлгийн үйлчилгээ, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэх ажлын санхүүжилтүүд сумдад тус тус хуваарилагдсан байна.

3.7 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд тайлант хугацаанд мэдээлбэл зохих 151 мэдээллээс 135 мэдээллийг хугацаанд нь, 3 мэдээллийн хугацаа болоогүй, 12 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг байршуулаагүй байна. Тухайлбал: Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хөтөлбөр, зориулалтын батлагдсан төсөв гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарыг бүтэн жилээр мэдээлээгүй байна.

Илрүүлэлт: Аймгийн хэмжээнд нийтлэгээр байгууллагаас гаргасан шийдвэрийг тухай бүр бүр мэдээлээгүй, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш орлого, зардлыг бүрэн мэдээлээгүй, батлагдсан жилийн төсвийг дутуу мэдээлсэн, төсөв орсон өөрчлөлтийг бүрэн мэдээлээгүй, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан, зарлагын гүйлгээ бүрд түүнд холбогдох эрх бүхий этгээдийн нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдээдлийг хавсаргаагүй, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг мэдээлээгүй, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээг мэдээлээгүй байна.

Тухайлбал Мэдээлээгүй зөрчлийг нэгтгэн хүснэгтээр харуулбал:

Д.д	Байгууллагын нэр	Зөрчлийн дүн	
		Мэдээлээгүй тоо	Мэдээлээгүй мөнгөн дүн /сая.төг/
1	Баян-Овоо ЕБС	9	0.50
2	Баян-Овоо Соёлын төв	8	40.00
3	Булган сумын Засаг даргын тамгын газар	39	684.90
4	Булган сумын Ерөнхий боловсролын сургууль	17	92.90
5	Гурван тэс сумын ерөнхий боловсролын сургууль	2	21.30
6	Гурвантэс сумын засаг даргын тамгын газар	75	2,119.00
7	Гурван тэс сумын соёлын төв	1	15.00
8	Мандал-овоо сумын Ерөнхий боловсролын сургууль	9	115.40
9	Мандал-овоо сумын засаг даргын тамгын газар	33	1,072.60
10	Манлай сумын Засаг даргын Тамгын газар	66	2,579.30
11	Манлай сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	16	55.60
12	Манлай сумын Ерөнхий боловсролын сургууль	6	114.70
13	Манлай сумын Соёлын төв	17	174.40
14	Номгон сум ЕБС	14	146.70
15	Номгон сум ЗДТГ	56	1,661.80
16	Номгон сум ИТХ	6	6.30
17	Ноён сумын ерөнхий боловсролын сургууль	12	278.40
18	Ноён сумын засаг даргын тамгын газар	37	918.50
19	Ноён сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал	15	68.90
20	Сэврэй сумын Ерөнхий боловсролын сургууль	14	231.00
21	Сэврэй сумын Засаг даргын тамгын газар	42	766.50
22	Сэврэй сумын Соёлын төв	6	32.90

23	Ханбогд сумын Засаг даргын тамгын газар	111	2,452.80
24	Ханбогд сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	7	13.40
25	Ханбогд сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургууль	15	171.70
26	Ханбогд сумын ерөнхий боловсролын сургууль	12	435.60
27	Ханбогд сумын соёлын төв	8	99.80
28	Ханхонгор сумын засаг даргын тамгын газар	19	130.90
29	Ханхонгор сумын соёлын төв	15	120.60
30	Ханхонгор сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал	1	6.30
31	Ханхонгор сумын МС-тай сургууль	3	52.30
32	Хүрмэн сумын засаг даргын тамгын газар	7	107.60
33	Хүрмэн сумын соёлын төв	1	6.80
34	Цогт-Овоо сумын Ерөнхий боловсролын сургууль	10	22.50
35	Цогт-Овоо сумын Засаг даргын тамгын газар	75	2,081.90
36	Цогтцэций 2-р сургууль	14	478.20
37	Цогтцэций 1-р сургууль	16	196.50
38	Даланзадгад сумын лаборатори нэгдүгээр сургууль	12	149.10
39	Өмнөговь аймгийн эрдмийн гэгээ сургууль	7	97.00
40	Даланзадгад сумын гуравдугаар сургууль	9	97.40
41	Даланзадгад сумын Засаг даргын тамгын газар	14	299.7
42	Даланзадгад сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал	6	23.10
43	Өмнөговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал	31	700.60
44	Өмнөговь аймгийн Хөгжимт жүжгийн театр	4	34.50
45	Өмнөговь аймгийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар	7	101.40
46	Өмнөговь аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт, аудитын алба	3	45.30
47	Өмнөговь аймгийн Боловсрол, соёл, урлагийн газар	6	126.90
Нийт дүн		913	19,248.50

3.8. ӨМНӨХ ЗӨВЛӨМЖИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААРХ ТАЙЛБАР, ТОДРУУЛГА

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 85.1 сая төгрөгийн 3 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлага зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		/сая төгрөг/ Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	3	85.1	2,8	85.1	0,2		92.0
Албан шаардлага	0	0	0	0			0
Төлбөрийн акт	0	0	0	0			0
Нийт	3	85.1	2,8	85.1	0,2		92.0

3.9 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 135 төсвийн байгууллага, 42 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 36 тусгайн сангийн, 15 төсвийн төвлөрүүлэн захирагч, нийт 228 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 149 байгууллагад дүгнэлт гаргаж, 61 байгууллага түүврээр хамрагдсан, 18 байгууллагад итгэл үзүүлсэн.

Байгууллагын нэр	Байгууллага нэгжийн тоо				Гаргасан санал дүгнэлтийн хэлбэр				
	Аудитад хамрагдах	Үүнэс: аудит хийсэн хэлбэр				Зөрчилгүй	Хязгаарлалтай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
		Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт	Итгэл үзүүлсэн	Аудит хийлгээгүй				
ТШЗ	135	108	12	15	86	20	2	0	
ОНТС	36		36						
УТҮГ	2	2			2				
ОНӨААН	38	22	13	3	21	1			
ОНӨОААН	2	2			2				
ТТЗ	15	15			7	8			
Нийт дүн	228	149	61	18	0	118	29	2	0

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 115, “Хязгаарлалттай” 29, “Сөрөг” 2 байгууллагад санал дүгнэлт өгсөн байна.

Хязгаарлалттай болон сөрөг дүгнэлт авсан байгууллагууд

№	Байгууллагын нэр	Ангилал	Дүгнэлтийн хэлбэр
1	Баяндалай сумын засаг даргын тамгын газар	ТШЗ	Хязгаарлалтай
2	Булган сумын ерөнхий боловсролын сургууль	ТШЗ	Хязгаарлалтай
3	Булган сумын засаг даргын тамгын газар	ТШЗ	Хязгаарлалтай
4	Манлай сумын засаг даргын тамгын газар	ТШЗ	Хязгаарлалтай
5	Номгон сумын засаг даргын тамгын газар	ТШЗ	Хязгаарлалтай
6	Номгон сумын ерөнхий боловсролын сургууль	ТШЗ	Хязгаарлалтай
7	Ноён сумын ерөнхий боловсролын сургууль	ТШЗ	Хязгаарлалтай
8	Ноён сумын засаг даргын тамгын газар	ТШЗ	Хязгаарлалтай
9	Сэврэй сумын засаг даргын тамгын газар	ТШЗ	Хязгаарлалтай
10	Сэврэй сумын Ерөнхий боловсролын сургууль	ТШЗ	Хязгаарлалтай
11	Ханбогд сумын Засаг даргын тамгын газар	ТШЗ	Хязгаарлалтай
12	Ханбогд сумын хоёрдугаар сургууль	ТШЗ	Хязгаарлалтай
13	Ханбогд сумын ерөнхий боловсролын сургууль	ТШЗ	Хязгаарлалтай
14	Ханхонгор сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал	ТШЗ	Хязгаарлалтай
15	Ханхонгор сумын засаг даргын тамгын газар	ТШЗ	Хязгаарлалтай
16	Ханхонгор сумын соёлын төв	ТШЗ	Хязгаарлалтай
17	Цогт-Овоо сумын засаг даргын тамгын газар	ТШЗ	Хязгаарлалтай
18	Цогтцэций сумын 6-р сургууль	ТШЗ	Хязгаарлалтай
19	Цогтцэций сумын соёлын төв	ТШЗ	Хязгаарлалтай

20	Даланзадгад сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал	ТШЗ	Хязгаарлалтай
21	Ханбогд сумын Хандизель	ОНӨААН	Хязгаарлалтай
22	Баян-Овоо сумын Засаг дарга	ТТЗ	Хязгаарлалтай
23	Гурвантэс сумын Засаг дарга	ТТЗ	Хязгаарлалтай
24	Мандал-Овоо сумын Засаг дарга	ТТЗ	Хязгаарлалтай
25	Манлай сумын Засаг дарга	ТТЗ	Хязгаарлалтай
26	Сэврэй сумын Засаг дарга	ТТЗ	Хязгаарлалтай
27	Ханбогд сумын засаг дарга	ТТЗ	Хязгаарлалтай
28	Цогт-Овоо сумын Засаг дарга	ТТЗ	Хязгаарлалтай
29	Цогтцэций сумын Засаг дарга	ТТЗ	Хязгаарлалтай
30	Манлай сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал	ТШЗ	Сөрөг
31	Даланзадгад сумын засаг даргын тамгын газар	ТШЗ	Сөрөг

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 93,947.0 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 30,940.9 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулж, 115.0 сая төгрөгийн зөрчилд 29 төлбөрийн акт тогтоож, 52,376.6 сая төгрөгийн зөрчилд 204 албан шаардлага хүргүүлж, 10,514.5 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 228 зөвлөмжийг хүргүүлсэн.

Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн залруулга

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг нэгтгэхдээ харьяа байгууллагуудын аудит хийсэн санхүүгийн тайлангаас зөрүүтэй нэгтгээгүй байна.

Аудитаар нийт 12,228.1 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс, 1,879.0 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 10,349.1 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 7 зөвлөмжийг хүргүүлээ.

Ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн албан шаардлага

1. Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс АЗДТГ-ын архивыг тоног төхөөрөмж худалдан авахад 18.0 сая төгрөг, Гурван сайхан орон сууцны корпорац ХХК-д 56 м.кв өрөөг засварлахад 9.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Сангийн сайдын 2018 оны 318 дүгээр тушаалын хавсралт "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.2 "Засаг даргын нөөц хөрөнгийг дараах байдлаар зарцуулахыг хориглоно", 2.2.1.2 "энэ журмын 2.1.1, 2.1.2-т зааснаас бусад зориулалтаар тоног төхөөрөмж бэлтгэх, хөрөнгө оруулалтын зардал гаргах" заалтыг хэрэгжүүлээгүй байна.

2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар төсвийн байгууллагуудын автомашин завсарлах, тохижилт, дэмжлэг, мод тарьж ургуулсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагад урамшуулал, ойн хөнөөлт шавж хортонтой тэмцэх зардал, ан амьтанд өвс тэжээлийн нөөц бүрдүүлсэн, аймгийн нутаг дэвсгэрт унах хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэх зэрэг нийт 153.8 сая төгрөгийн урсгал шинжтэй зардлыг санхүүжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24 "хөрөнгө оруулалт" гэдэг нь төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг", 58 дугаар зүйлийн 58.2.3 "орон нутгийн өмчийн барилга байгууламжийн их засвар, шинээр өмч бий болгох, хөрөнгө оруулалт хийх" дахь заалтыг тус тус хэрэгжүүлээгүй байна.

3. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн төсөл арга хэмжээг түүвэрлэн шалгахад зураг төсвийн компанийг шалгаруулахдаа, ажлын чадвар, туршлага дутмаг компани шалгаруулсан, үүнээс шалтгаалж зурагт байгаа ажлыг төсөвт тусгаагүй,

инженер геологийн дүгнэлт гаргахдаа газар дээр нь ирж гүйцэтгээгүйн улмаас суурийн зурагт өөрчлөлт орсон, зураг төсөв гүйцэтгэхдээ алдаа гарган гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалсан ажилд 127.4 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулсан.

Энэ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.3 "нэмэлт нийлүүлэлт нь анхны гэрээний үнийн 20 хувиас хэтрэхгүй нөхцөлд анхны гэрээний дагуу нийлүүлсэн бараа, тоног төхөөрөмжийн зарим хэсгийг солих, засварлах болон нэмж нийлүүлэх үед нийлүүлэгчийг өөрчлөх нь захиалагч өөр төрлийн техникийн үзүүлэлттэй материал авахад хүрэх, энэ нь ашиглалт болон засвар үйлчилгээнд техникийн хүндрэл учруулах, эсхүл үргүй зардал гаргахаар бол" дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.

4. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 24 төсөл арга хэмжээ буюу 1,569.9 сая төгрөгийн төсөл арга хэмжээг иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдээгүй нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6 "орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ", Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 3 дугаар хэсгийн 3.1.2 "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх" дахь заалтыг хэрэгжүүлээгүй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчид 10,349.1 сая төгрөгийн алдаа, зөрчилд өгсөн 7 зөвлөмжийг менежментийн захидалд дурдсан болно.

3.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Цар тахлын дэгдэлтэй холбоотойгоор хөрөнгө оруулалт болон ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл арга хэмжээг түүвэрлэн авч үзсэн тул цаашид гүйцэтгэл, нийцлийн аудитаар дэлгэрэнгүй авч үзэх нь зүйтэй гэж үзлээ

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Орон нутгийн төсвийн орлогод төвлөрөх бичил худалдаа, ажил, үйлчилгээний орлогоос сард төлөх албан татварын хувь хэмжээг тогтоож, орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлээгүй байна.

Эрсдэл: Татварын хуулийг хэрэгжүүлэхгүй байх

Өгсөн зөвлөмж: Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2.д"хуульд заасан хязгаар, шаардлагад нийцүүлэн орон нутгийн зарим татвар, төлбөр, хураамжийн хувь хэмжээг тогтоох", Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4 "Энэ хуулийн 12.1.3-т заасан орлого олж байгаа хувь хүний сард төлөх албан татварын хэмжээг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал доор дурдсан хязгаарт багтаан тогтооно" гэж заасныг хэрэгжүүлж ажиллах

Байгууллагаас өгсөн харуу, тайлбар: Орон нутгийн төсвийн орлогод төвлөрөх бичил худалдаа, ажил, үйлчилгээний орлогоос сард төлөх албан татварын хувь хэмжээг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулахаар бичил бизнес эрхлэгч иргэдээс санал авч, тогтоолын төслийг боловсруулсан болно.

Илрүүлэлт 2: Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 9,785.6 сая төгрөгөөр тасалдуулсан байна.

Эрсдэл: Төсвийн өр, авлага их хэмжээгээр үүсэх, дараа жилийн орлогын төлөвлөлтөд нөлөөлөх

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 14 дүгээр зүйлийн 14.3 "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна" гэж заасныг хэрэгжүүлэх.

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Коронавируст халдвар КОВИД-19 цар тахлын улмаас Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн 178 дугаар тогтоолоор бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжиж, улмаар 2020 оныг дуустал хөл хорио тогтоосон шат дараалсан арга хэмжээнүүдийг авч улс, аймаг, сумдын хоорондох иргэдийн зорчих хөдөлгөөнийг хязгаарласнаас шалтгаалан Таван толгой ХК-ны ногдол ашгийн орлого тасарсан. Цаашид аймгийн ИТХ-аар баталсан орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллахад анхаарч ажиллана.

Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт : Аймгийн ИТХ-ын 2019 оны 9/6, 2020 оны 2/7 дугаар тогтоолоор бүх шатны иргэдийн төлөөлөгчдийн хурал нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 211.1 сая төгрөгийг өөрийн төсөвтөө батлуулж, 188.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Эрсдэл: Хууль тогтоомж хэрэгжихгүй байх, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах

Өгсөн зөвлөмж: Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.8 "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд зориулсан хөрөнгийн төлөвлөлт, хуваарилалт, зарцуулалтад Зохицуулах зөвлөл, төрийн аудитын байгууллага, санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон төсвийн тухай хууль тогтоомжид заасан эрх бүхий этгээд хяналт тавина."-д болон Хууль зүйн сайд, Сангийн сайдын хамтарсан 1998 оны 88/152 дугаар тушаалаар батлагдсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам"-ын 7 "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан тусгай дансанд төвлөрүүлсэн хөрөнгийг сум, дүүргийн Зөвлөлийн шийдвэрийг үндэслэн тухайн шатны Засаг даргын захирамжаар дараах зориулалтаар зарцуулна", 12 "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлын байгуулалт, зарцуулалтад тухайн шатны Хурал, санхүүгийн хяналт шалгалтын байгууллага хяналт тавина"-т заасныг хэрэгжүүлж ажиллах

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2020 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн Засаг даргын 2020 оны 22, 18, 04, 10 тоот удирдамжаар аймгийн ИТХ, Гурвантэс, Цогтцэций, Ханбогд сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 100 хувь хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн ба 15 сумын ИТХ бага эрсдэлтэй үнэлэгдэж шалгагдаагүй болно. Мөн Хууль зүйн сайд, Сангийн сайдын хамтарсан 1998 оны 88/152 дугаар тушаалаар батлагдсан "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан орон нутгийн төсвөөс санхүүжилт олгох, зарцуулах, тайлагнах журам"-ыг батлахад үндэслэсэн 1997 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн Гэмт

хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийг 2019 оны 6 сард хүчингүй болгож, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгыг мөрдөж байна.

Өр, авлагын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт : Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа ОНӨОААН, ОНӨААТҮГ-ууд нь тайлант онд дансны авлага 16,416.6 сая төгрөг, татвар, НДШ-ийн авлага 630.2 сая төгрөг, ажиллагсадтай холбоотой, байгууллага, хувь хүмүүс болон төлбөртэй үйлчилгээний авлагын 479.6 сая төгрөг нийт 17,526.4 төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, дансны өглөг 13,247.1 сая төгрөг, татварын өглөг 24,924.3 сая төгрөг, ногдол ашгийн өглөг 11,990.1 сая төгрөг, бусад хөрөнгө бэлтгэхтэй холбоотой өглөг, зээлийн хүү, ажиллагсад, байгууллага, хувь хүмүүстэй холбоотой 1,276.4 сая төгрөг нийт 51,437.9 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.

Эрсдэл: Алдагдалтай ажиллах, үр ашиг буурах

Өгсөн зөвлөмж: Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2 "эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж, хүргэх түвшин", 20 дугаар зүйлийн 20.1.3 "үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах" –д заасныг хэрэгжүүлж ажиллах.

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: УСНББОУС 1-д Санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн ба мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой. Үнэн зөв толилуулга нь ажил гүйлгээний нөлөөг УСНББОУС-д тодорхойлсны дагуу хөрөнгө, өр төлбөр, орлого зардлаар тодорхойлж хүлээн зөвшөөрч шударгаар илэрхийлэхийг шаарддаг. Энэхүү стандартын дагуу төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа ОНӨААТҮГ-ууд нь заасны дагуу дагуу өр авлагыг хүлээн зөвшөөрч бүртгэсэн болно. Үүнээс гадна нийт өр авлагын 89.2 хувийг зөвхөн орон нутгийн 51 хувийн өмчит Таван толгой ХК, Гүний ус ХК эзэлж байгаа бөгөөд үүнд 49 хувийн хувь оролцооны авлага өглөг хамт байгаа бөгөөд энэ 2 компани 2020 онд "Зөрчилгүй" санал дүгнэлт авсан болно.

Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт 1: Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 2 хүнд 20.0 сая төгрөгийн орон сууцны дэмжлэг, 1 хүнд 20.0 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг, 2 хүнд 12.6 сая төгрөгийн 6 сарын цалинтай тэнцэх нэг удаагийн тэтгэмж, Засаг даргын тамгын газрын дарга болон нийтлэг үйлчилгээний газрын даргын албан үүргийг гүйцэтгэсэн 2 албан тушаалтанд 0.6 сая төгрөгийн үндсэн цалингийн 40 хувьтай тэнцэх дэмжлэгийг хавтгайруулан олгосон байна.

Эрсдэл: Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах" заалтыг хэрэгжүүлж ажиллах.

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Байгууллага иргэдийн хүсэлтийг тус тус үндэслэж шийдвэрлэсэн. Цаашид анхаарч ажиллана.

Илрүүлэлт 2: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 322.3 сая төгрөгийн төсөл арга хэмжээг аймгийн ИТХ-аар батлуулаагүй санхүүжүүлсэн байна.

Эрсдэл: Хууль тогтоомжийг зөрчих, зөрчил дахин давтагдах

Өгсөн зөвлөмж: Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 2 дугаар хэсгийн 2.7 "энэ журмын 2.5 ба 2.6-д заасан ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ бүрийг тухайн шатны ИТХ хэлэлцэн батална" -д заасныг хэрэгжүүлж ажиллах.

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Цаашид анхаарч ажиллах болно.

Шилэн дансны хуулийн хэрэгжилтэй холбоотой асуудал

Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг тулган баталгаажуулахад тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 135 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроосон 12 мэдээлэл, 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Эрсдэл: Хуулийг цаг хугацаанд хэрэгжүүлэхгүй байх

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй” –г цаг хугацаанд нь хэрэгжүүлэх.

Байгууллагаас өгсөн хариу, тайлбар: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 9 дүгээр сарын 15-ны дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Өмнөговь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч	Аудитын код:
2020,12,31		Өмнөговь аймгийн Засаг дарга	ӨМА-2021/1/СТА-ТЕЗ
Шалгагдсан байгууллагын нэр:			Сая төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллага ас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
1	Орон нутгийн төсвийн орлогод төвлөрөх бичил худалдаа, ажил, үйлчилгээний орлогоос сард төлөх албан татварын хувь хэмжээг тогтоож, орон нутгийн төсвийн орлогод төвлөрүүлээгүй	0	Зөвлөмж	Засаг дарга Ерөнхий санхүүч	Р.Сэддорж С.Уранчимэг
2	Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөг 9,785.6 сая төгрөгөөр тасалдуулсан байна	9,785.6	Зөвлөмж	Засаг дарга Ерөнхий санхүүч	Р.Сэддорж С.Уранчимэг
3	Аймгийн ИТХ-ын 2019 оны 9/6, 2020 оны 2/7 дугаар тогтоолоор бүх шатны иргэдийн төлөөлөгчдийн хурал нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардалд 211.1 сая төгрөгийг өөрийн төсөвтөө батлуулж, 188.0 сая төгрөгийг зарцуулсан.	188.0	Зөвлөмж	Засаг дарга Ерөнхий санхүүч	Р.Сэддорж С.Уранчимэг
4	Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа ОНӨОААН, ОНӨААТҮГ-ууд нь тайлант онд дансны авлага 16,416.6 сая төгрөг, татвар, НДШ-ийн авлага 630.2 сая төгрөг, ажиллагсадтай холбоотой, байгууллага, хувь хүмүүс болон төлбөртэй үйлчилгээний авлагын 479.6 сая төгрөг нийт 17,526.4 төгрөгийн авлагын үлдэгдэлтэй, дансны өглөг 13,247.1 сая төгрөг, татварын өглөг 24,924.3 сая төгрөг, ногдол ашгийн өглөг 668.9 сая төгрөг, бусад хөрөнгө бэлтгэхтэй холбоотой өглөг, зээлийн хүү, ажиллагсад, байгууллага, хувь хүмүүстэй холбоотой 1,276.4 сая төгрөг нийт 40,116.7 сая төгрөгийн богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэлтэй байна.	0	Зөвлөмж	Засаг дарга Ерөнхий санхүүч	Р.Сэддорж С.Уранчимэг
5	Засаг даргын нөөц сангийн хөрөнгөөс АЗДТГ-ын архивыг тоног төхөөрөмж худалдан авахад 18.0 сая төгрөг, Гурван сайхан орон сууцны корпорац ХХК-д 56 мкв өрөөг засварлахад 9.9 сая төгрөгийг зарцуулсан байна.	27.9	Албан шаардлага	Засаг дарга Ерөнхий санхүүч	Р.Сэддорж С.Уранчимэг
6	Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 2 хүнд 20.0 сая төгрөгийн орон сууцны дэмжлэг, 1 хүнд 20.0 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг, 2 хүнд 12.6 сая төгрөгийн 6 сарын цалинтай тэнцэх нэг удаагийн тэтгэмж, Засаг даргын тамгын газрын даргын болон нийтлэг үйлчилгээний газрын даргын албан үүргийг гүйцэтгэсэн 2 албан тушаалтанд 0.6 сая төгрөгийн үндсэн цалингийн 40 хувьтай тэнцэх дэмжлэгийг хавтгайруулан олгосон байна.	53.2	Зөвлөмж	Засаг дарга Ерөнхий санхүүч	Р.Сэддорж С.Уранчимэг

7	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийсэн төсөл арга хэмжээг түүвэрлэн шалгахад зураг төсвийн компанийг шалгаруулахдаа, ажлын чадвар, туршлага дутмаг компани шалгаруулсан, үүнээс шалтгаалж зурагт байгаа ажлыг төсөвт тусгаагүй, инженер геологийн дүгнэлт гаргахдаа газар дээр нь ирж гүйцэтгээгүйн улмаас суурийн зурагт өөрчлөлт орсон, зураг төсөв гүйцэтгэхдээ алдаа гарган гүйцэтгэгчийн буруутай үйл ажиллагаанаас шалтгаалсан ажилд 127.4 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулсан.	127.4	Албан шаардлага	Засаг дарга Ерөнхий санхүүч	Р.Сэддорж С.Уранчимэг
8	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг шалгахад аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст 9.9 сая төгрөг, Мандал-Овоо сумын ЗДТГ-т автомашины засварт 5.0 сая төгрөг, Цогт-Овоо сумын Засаг даргын тамгын газрын автомашиныг засварлахад 14.5 сая төгрөг, ЗХ-ний 148 дугар тусгай ротын засварт 9.9 сая төгрөг, гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын тохижилтод 9.9 сая төгрөг, Номгон сумын ЗДТГ дэмжлэгт 32.0 сая төгрөг, Мод тооллогын ажлын зардал, Мод тарьж ургуулсан иргэн аж ахуйн нэгж байгууллагад журмын дагуу урамшуулал, ойн хөнөөлт шавж хортонтой тэмцэх зардлуудад 54.0 сая төгрөг, ан амьтанд өвс тэжээлийн нөөц бүрдүүлэхэд 8.7 сая төгрөг, аймгийн нутаг дэвсгэрт унах хур тунадасны хэмжээг нэмэгдүүлэхэд 9.9 сая төгрөг, нийт 153.8 сая төгрөгийн урсгал зардалд зарцуулсан.	153.8	Албан шаардлага	Засаг дарга Ерөнхий санхүүч	Р.Сэддорж С.Уранчимэг
9	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн 24 төсөл арга хэмжээ буюу 1,569.9 сая төгрөгийн төсөл арга хэмжээг иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдээгүй.	1,569.9	Албан шаардлага	Засаг дарга Ерөнхий санхүүч	Р.Сэддорж С.Уранчимэг
10	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 322.3 сая төгрөгийн төсөл арга хэмжээг аймгийн ИТХ-аар батлуулаагүй санхүүжүүлсэн.	322.3	Зөвлөмж	Засаг дарга Ерөнхий санхүүч	Р.Сэддорж С.Уранчимэг
11	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг тулган баталгаажуулахад тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 135 мэдээлэл, хугацаа болоогүй 3 мэдээлэл, хугацаа хоцроосон 12 мэдээлэл, 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй.	0	Зөвлөмж	Засаг дарга Ерөнхий санхүүч	Р.Сэддорж С.Уранчимэг
Дүн		12,228.1			